



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 04 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны 2000 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 03 дугаар тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл (орон тооны бус)-ийн дүрэм”-ийн 1 дүгээр зүйлийн 1.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.1.2, 3.1.3, Засгийн газрын 2017 оны 112 дугаар тогтоолоор баталсан “Элэг бүтэн Монгол хөтөлбөр”-ийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах журам”-ыг нэгдүгээр хавсралт, “Даатгуулагчийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний багц”-ыг хоёрдугаар хавсралт, “Даатгуулагчийн эрүүл мэндийн үзлэгийн хуудас”-ны загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний багцын төлбөрийн хэмжээг 50000 /тавин мянга/ төгрөгөөр, 40-65 насны даатгуулагчийн элэгний В, С вирүсийг илрүүлэх шинжилгээний төлбөрийн хэмжээг 2800 /хоёр мянга найман зуу/-төгрөгөөр тус тус тогтоосугай.

3. Даатгуулагчийг элэгний В, С вирүсийн илрүүлэг, шинжилгээнд хамруулах журмыг хамтран батлахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Н.Номтойбаяр, Эрүүл мэндийн сайд А.Цогцэцэг нарт, илрүүлэг шинжилгээг 2017 оны батлагдсан төсөвт багтаан 2017 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор зохион байгуулахыг Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар /Д.Зоригт/-т тус тус зөвшөөрсүгэй.

4. Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах ажлыг товлот хугацаанд чирэгдэлгүй, шуурхай зохион байгуулахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Ундрал/, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газар /Я.Буянжаргал/, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар /Д.Зоригт/-т, Эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал, ерөнхий эмч нарт тус тус даалгасугай.


1000033

5. Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах, тусламж үйлчилгээний чанарт хяналт тавьж, холбогдох програм хангамжид өөрчлөлт оруулж ажиллахыг Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар /Д.Зоригт/, Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д тус тус үүрэг болгосугай.

6. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар /Ц.Мөнхзул/, Эрүүл мэндийн яамны Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Баярт/, Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн Ажлын алба /Б.Батбилэгт/-нд тус тус даалгасугай.

ДАРГА  Н.НОМТОЙБАЯР

Нийгмийн даатгалын үндэсний
зөвлөлийн 2017 оны 05 дугаар сарын
04-ний өдрийн 11 дугаар тогтоолын
нэгдүгээр хавсралт



ДААТГУУЛАГЧИЙГ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРТ ИЛРҮҮЛЭХ ҮЗЛЭГ, ОНОШИЛГОО, ШИНЖИЛГЭЭНД ХАМРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд түүний нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд үндэслэн, тогтоосон товлोलт хугацаанд хамруулах, эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь санхүүжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэ журмыг даатгуулагч болон нийгмийн даатгалын байгууллага, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний тусламж, үйлчилгээг даатгуулагчид үзүүлэхээр даатгалын гэрээ байгуулсан эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.

1.3. Эрүүл мэндийн даатгалын сангаас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний зардалд олгох төлбөрийн хэмжээг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батлана.

1.4. Даатгуулагчид урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагыг Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9.11-д заасныг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн баталсан журмын дагуу Нийгмийн даатгалын байгууллага сонгон шалгаруулна.

1.5. Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан 40, 45, 50, 55, 60, 65 настай даатгуулагч урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдана.

1.6. Эрүүл мэндийн байгууллага нь энэхүү журмын 1.5-д заасан нөхцлийг хангаагүй даатгуулагчид урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний тусламж, үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас олгохгүй.

Хоёр. Нийгмийн даатгалын байгууллагын эрх, үүрэг

2.1. Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах үйл ажиллагааг Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар болон орон нутагт эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс тус тус удирдан зохион байгуулна.

2.2. Журмын 1.4-д заасан сонгон шалгаруулах үйл ажиллагааг төсвийн төсөл, төсөөлөл боловсруулах хугацаанаас өмнө зохион байгуулж, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг төсвийн төсөлд тусгуулна.

2.3. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдах товлोलт хугацааг тогтоож, даатгуулагчид урьдчилан мэдэгдэнэ.

2.4. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах үйл ажиллагаанд ашиглах програм хангамжийг нэвтрүүлэх, үзлэгт хамрагдах даатгуулагчийн мэдээллийг жил бүрийн 01 дүгээр сарын 15-ны дотор шинэчилнэ.

2.5. Даатгуулагчид үзүүлсэн тусламж, үйлчилгээний чанар, эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн зардлын нэхэмжлэлийг даатгуулагч бүрээр шалгаж, төлбөрийг гэрээнд заасан хугацаанд шилжүүлнэ.

2.6. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний хамралтын мэдээ, тайланг улирал бүр гаргаж нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

2.7. Тайлант жилд үзүүлсэн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний хамралтын тайлан, үр дүн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг дараа жилийн нэгдүгээр улиралд багтаан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд танилцуулна.

2.8. Эрүүл мэндийн даатгалын ач холбогдлыг сурталчлах, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах ажлыг эрүүл мэндийн байгууллагатай хамтран зохион байгуулна.

2.9. Нийгмийн даатгалын байгууллага, ажилтан нь тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллага, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний багц /цаашид багц гэх/-ын талаарх мэдээллээр даатгуулагчийг хангана.

Гурав. Даатгуулагчийн эрх, үүрэг

3.1. Энэхүү журмын 1.5-д заасан даатгуулагч урьдчилан сэргийлэх тусламж, үйлчилгээний багцаас зөвхөн нэгийг сонгон товлोलт хугацаанд хамрагдана.

3.2. Даатгуулагч төвлосон хугацаанд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний багцад хамрагдах тохиолдолд өөрөөсөө аливаа төлбөр төлөхгүй.


3.3. Даатгуулагч нь эрүүл мэндийн даатгалын гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагаар харьяалал харгалзахгүй үйлчлүүлэх эрхтэй.

3.4. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний талаарх мэдээллийг нийгмийн даатгалын байгууллага, ажилтан, www.ndaatgal.mn цахим хуудас, даатгалын гэрээтэй эрүүл мэндийн байгууллагаас авна.

3.5. Нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа, тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар санал, гомдлоо холбогдох байгууллагад гаргаж болно.

3.6. Даатгуулагч нь энэ журмын 3.1-д заасан тусламж, үйлчилгээ авахдаа дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.

- 3.6.1. Эрүүл мэндийн даатгалын гэрчилгээ
- 3.6.2. Иргэний үнэмлэх
- 3.6.3. Амбулаторийн үзлэгийн карт



3.7. Даатгуулагч нь нийгмийн даатгалын байгууллагаас зарласан товлолт хугацаанд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдаагүй тохиолдолд нөхөн хамруулахгүй.

Дөрөв. Эрүүл мэндийн байгууллагын эрх, үүрэг

4.1. Энэ журмын 1.4-т заасан сонгон шалгаруултад тэнцэж, даатгалын байгууллагатай даатгалын гэрээ байгуулсан байна.

4.2. Эрүүл мэндийн байгууллага нь даатгуулагчид эмнэл зүйн заавар, стандартын дагуу чанартай, аюулгүй, тэгш, хүртээмжтэй тусламж, үйлчилгээг нэмэлт төлбөргүй, харьяалал харгалзахгүй үзүүлнэ.

4.3. Даатгалын гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллага нь даатгуулагчид тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ даатгуулагчийн иргэний үнэмлэх, эрүүл мэндийн даатгалын гэрчилгээг үндэслэн www.ndaatal.mn цахим хуудаснаас "Даатгуулагчийн эрүүл мэндийн үзлэгийн хуудас"-ыг 2 хувь хэвлэн, оношилгоо, шинжилгээний хариу болон дүгнэлт, зөвлөгөөг бичиж нэг хувийг даатгуулагчид өгнө.

4.4. Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний багц, төлбөрийн мэдээллийг ил тод, ойлгомжтой хэлбэрээр байршуулан даатгуулагчийг мэдээллээр хангана.

4.5. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдсан даатгуулагчийн нэрсийн жагсаалтыг Эрүүл мэндийн сайдын 2010 оны 17 дугаар тушаалын хавсралт АМ-1А маягтаар батлагдсан "Амбулаториор үзүүлсэн тусламж үйлчилгээ" гэсэн хүснэгтийн загвараар амбулаторийн бусад үзлэгээс тусад нь гаргаж цаасаар болон файлаар, "Даатгуулагчийн эрүүл мэндийн үзлэгийн хуудас"-ны үлдэх хувь, зардлын нэхэмжлэлийн хамт харилцагч нийгмийн даатгалын байгууллагад гэрээнд заасан хугацаанд хүргүүлнэ.

4.6. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний тусламж, үйлчилгээ үзүүлсэн даатгуулагчийн тоо, мэдээ, үр дүнгийн тайланг хагас, бүтэн жилээр гаргаж харилцагч нийгмийн даатгалын байгууллагад хүргүүлнэ.

Тав. Бусад

5.1. Энэ журмыг зөрчсөн тохиолдолд буруутай байгууллага, албан тушаалтан, даатгуулагчид хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

5.2. Журамд тусгагдаагүй бусад асуудлыг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн даатгалын гэрээгээр зохицуулна.

Нийгмийн даатгалын үндэсний
зөвлөлийн 2017 оны 05 дугаар сарын
04-ний өдрийн 11 дугаар тогтоолын
хоёрдугаар хавсралт

1116125031 5284708

ДААТГУУЛАГЧИЙН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРТ ИЛРҮҮЛЭХ
ҮЗЛЭГ ОНОШИЛГОО, ШИНЖИЛГЭЭНИЙ БАГЦ

Нэгдүгээр багц: Дотор эрхтний архаг өвчлөлийг илрүүлэх

№	Үзлэг шинжилгээ	Хүйс	
		эр	эм
1	Биохимийн шинжилгээ (Алат, Асат, Билирубин, гаммаглутамил трансфераза, сахар, холестерол) креатинин	+	+
2	Элэгний хавдар илрүүлэх /AFP-тооны аргаар/	+	+
3	Хэвлийн эхо, бамбай, умайн дайвар		+
4	Хэвлийн эхо, бамбай, түрүү булчирхай,	+	
5	Хеликобактери /HP IgG/ -тооны аргаар	+	+
6	Эмчийн үзлэг зөвлөгөө	+	+

Хоёрдугаар багц: Дотор эрхтний архаг өвчлөл болон үе мөчний эмгэг илрүүлэх

№	Үзлэг шинжилгээ	Хүйс	
		эр	эм
1	Биохимийн шинжилгээ (Алат, Асат, Билирубин, гаммаглутамил трансфераза, сахар, холестерол) креатинин	+	+
2	Хэвлийн эхо, бамбай	+	+
3	Үе мөч /С реактивный белок, АСЛО, ревматоидный фактор/	+	+
4	Эрдсийн Натри, Кали, Кальци	+	+
5	Эмчийн үзлэг зөвлөгөө	+	+

Гуравдугаар багц: Хавдрын эрт илрүүлэг

№	Үзлэг шинжилгээ	Хүйс	
		эр	эм
1	Биохимийн шинжилгээ (Алат, Асат, Билирубин, гаммаглутамил трансфераза, сахар, холестерол) креатинин	+	+
2	Ходоодны хавдар илрүүлэх /CA-72-4 тоон аргаар/	+	+
3	Умайн хүзүүний эсийн шинжилгээ		+
4	Түрүү булчирхайн хавдрын маркер PSA	+	
5	Эмчийн үзлэг зөвлөгөө	+	+

Нийгмийн даатгалын үндэсний
зөвлөлийн 2017 оны 05 дугаар сарын
04-ний өдрийн 11 дугаар тогтоолын
гуравдугаар хавсралт

1116125031 ☎ 5284708



ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

**ДААТГУУЛАГЧИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ҮЗЛЭГИЙН ХУУДАС**

Дугаар

Овог: Нэр:

Регистрийн дугаар: Хүйс: эрэгтэй эмэгтэй

ЭМД-ын гэрчилгээний дугаар: Сонгосон багцын дугаар:

Оршин суугаа хаяг:

Утасны дугаар

Тусламж, үйлчилгээ үзүүлсэн эрүүл мэндийн байгууллагын нэр:

	Үзлэг шинжилгээ	Шинжилгээний хариу	Эмчийн гарын үсэг
1			
2			
3			
4			
...			

ЭМЧИЙН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨГӨӨ

.....
.....
.....
.....

ГАРЫН ҮСЭГ

ЭМЧ

ДААТГУУЛАГЧ

...../

/

...../

/

Тамга /тэмдэг/

20... оны.....сар.....өдөр

ДААТГУУЛАГЧИЙГ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЭРТ ИЛРҮҮЛЭХ
ҮЗЛЭГ ОНОШИЛГОО, ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНИЙН САНАЛ



Нэгдүгээр багц

№	Үзлэг шинжилгээ	Зах зээлийн жишиг үнэ		ЭМД-аас санал болгож буй үнэ
		эр	эм	
1	Биохимийн шинжилгээ (Алат, Асат, Билирубин, гаммаглутамил трансфераза, сахар, холестерол) креатинин	18 000	18 000	50 000
2	Элэгний хавдар илрүүлэх /AFP-тооны аргаар/	15 000	15 000	
3	Хэвлийн эхо, бамбай, өндгөвч		15 000	
4	Хэвлийн эхо, бамбай, түрүү булчирхай,	15 000		
5	Хеликобактери /HP IgG/ -тооны аргаар	3 000	3 000	
6	Эмчийн үзлэг зөвлөгөө	15 000	15 000	
НИЙТ ҮНЭ		66 000	66 000	

Хоёрдугаар багц

№	Үзлэг шинжилгээ	Зах зээлийн жишиг үнэ		ЭМД-аас санал болгож буй үнэ
		эр	эм	
1	Биохимийн шинжилгээ (Алат, Асат, Билирубин, гаммаглутамил трансфераза, сахар, холестерол) креатинин	18 000		50 000
2	Хэвлийн эхо, бамбай	12 000		
3	Үе мөч /С реактивный АСЛО, ревматоидный фактор/	15 000		
4	Эрдсийн Натри, Кали, Кальци	8 000		
5	Эмчийн үзлэг зөвлөгөө	15 000		
НИЙТ ҮНЭ		68 000		

Гуравдугаар багц

№	Үзлэг шинжилгээ	Зах зээлийн жишиг үнэ		ЭМД-аас санал болгож буй үнэ
		эр	эм	
1	Биохимийн шинжилгээ (Алат, Асат, Билирубин, гаммаглутамил трансфераза, сахар, холестерол) креатинин	18 000	18 000	50 000
2	Ходоодны хавдар илрүүлэх /CA-72-4 тоон аргаар/	20 000	20 000	
3	Умайн хүзүүний өмөнгийн хавдрын эсийн шинжилгээ		15 000	
4	Түрүү булчирхайн хавдрын маркер PSA	16 000		
5	Эмчийн үзлэг зөвлөгөө	15 000	15 000	
НИЙТ ҮНЭ		69 000	68 000	